



“ХАЙ БИ ОЙЛ” ХК

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”- ИЙН ХАГАС
ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот, 2025 он

1. Үнэлгээний зорилго

2.

- 2.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 2.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 2.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилд тооцно.
- 2.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 2.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

3. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		100
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4		
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4		
5	Эрсдэлийн удирдлага	8	5		
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	3		
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	6		
8	Компанийн соёл	6	6		
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	6		
	Нэгдсэн дүн	72	54		

4.Үнэлгээний аргачлал

4.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

4.2.Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

4.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

4.2.2. 70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;

4.2.3. 50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;

4.2.4. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

5. Үнэлгээний асуулга

“Хай Би Ойл” ХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журам болон залгамж халааны бодлоготой	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүй тусгаж ажилладаг.	1	50%
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн журмыг баталсан.	1	50%

5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн шинээр сонгогдсон гишүүдийг сонгогдсон өдрөөс эхлэн компанийн холбогдох бүх мэдээлэлтэй танилцах боломжоор хангаж ажилладаг төдийгүй тус гишүүд компанийн засаглалын сургалтад сууж, гэрчилгээ авдаг.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу хариуцлага хүлээдэг. ТУЗ-ын тайланг хүргүүлэв.	2	100%
ДҮН				10	83%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Биелүүлж ажилладаг.	Компанийн дүрмээр ТУЗ нь 1/3-с дээш хараат бус гишүүнтэй байхаар зохицуулсан. Одоогийн байдлаар ТУЗ 9 гишүүнтэй, үүний 3 нь хараат бус гишүүний үүрэг гүйцэтгэж байна.	2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Биелүүлж ажилладаг.	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн. Аудитын хорооны үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай. Тогтоолыг хүргүүлэв.	2	100%
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Биелүүлж ажилладаг.	Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд ердийн гишүүн. 2025 оноос эхлэн шинээр дэд хороодыг томилоход хараат бус гишүүн томилон ажиллана. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааг тухайлан зохицуулсан журамтай. Тогтоолыг хүргүүлэв.	2	100%

10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд ердийн гишүүн. 2025 оноос эхлэн шинээр дэд хороодыг томилоход хараат бус гишүүн томилон ажиллана. Нэр дэвшүүлэх хороо, залгамж халааны бодлогын баримт бичигтэй.	2	100%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Биелүүлсэн.	“ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ийн хүрээнд ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Одоогийн байдлаар компанийн ТУЗ нь өөрийн дэргэдэх аудит, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хүрээнд холбогдох зөвлөмжүүдийг хангалттай түвшинд өгч байгаа тул бусад чиг үүрэг бүхий хороодыг байгуулах шаардлага төдийлөн үүсээгүй байна.	2	100%
ДҮН				10	%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	Компани нь мэдээллийн үйл ажиллагааны журмын хүрээнд улирал, хагас жил болон жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан, бусад тогтмол болон тухай бүр мэдээлэх мэдээллийг арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээллэж ажилладаг.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэсэгчлэн хэрэгжсэн.	ТУЗ-ийн нарийн бичгээр дамжуулан компанийн бичиг баримттай танилцах эрх хөрөнгө оруулагчдад нээлттэй байдаг. Цаашид холбогдох баримт бичгийг нийтэд хүргэх сувгийг тэлэхийг зорино.	1	50%

14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Компани нь улирал бүрийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг НББОУС болон СТОУС ын дагуу бэлтгэдэг. Мөн жил бүрийн санхүүгийн тайланд Санхүүгийн Зохицуулах Хорооны бүртгэлтэй аудитын компаниар аудит хийлгэж, санхүүгийн тайлагналыг хуульд заасан хугацаа, агуулга, хэлбэрээр бодитоор илэрхийлж, бүрэн тайлбартайгаар МХБ болон өөрийн вэб сайтаар дамжуулан нийтэд мэдээлдэг.	1	50%
ДҮН				4	%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	Компани нь жил бүр Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэлтэй аудитын компаниар санхүүгийн тайланд аудит хийлгэх үүргээ биелүүлж ажиллаж байна.	2	100%
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэсэгчилэн хэрэгжүүлэ байна.	Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн ерөнхий нягтлан бодогч аудитын дүгнэлтийг танилцуулдаг. Аудитын хувьд дүгнэлт болон санхүүгийн үр дүнг цаасаар ирүүлэн хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангаж байна.	1	50%
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Цаашид хэрэгжүүлж ажиллана.	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд зохих мэдээллийг тусгаж, МХБ-ийн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулагчдад мэдээллэж ажиллана.	1	50%
ДҮН				4	%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэсэгчилэн хэрэгжүүлсэн.	Аудитын хорооны үйл ажиллагааны журамд заасны дагуу аудитын хороо нь компанийн үйл ажиллагаа, санхүү, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянадаг. Хорооны дарга гишүүн томилсон тогтоолыг хавсаргав.	1	50%
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давамжгийн талаар тогтмол тайлагнана.	Хэсэгчилэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байдаг. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зүгээс тухай бүр эрсдэлийг үнэлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	1	50%
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжүүлэггүй.	Компани өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй гадаад эрсдэлүүд болон эрсдэлийн удирдлагын талаар үйл ажиллагааны тайланд тусгаж ажиллана.	1	50%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжүүлсэн.	Бүтэц, бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг байхгүй бөгөөд хавсаран гүйцэтгүүлэх тушаалыг 2025 ондоо багтаан гаргах болно. Зааварыг 2023 онд батлсан бөгөөд 2023.06.12 нд хүргүүлсэн.	2	100%
ДҮН				5	%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Хэсэгчилэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн гишүүдэд цалин олгодоггүй бөгөөд 2025 оны ХЭХ аар ТУЗ-ын төсөв баталсан бөгөөд холбогдох шийдвэрийг хурлын материалын хамт 2025.05.20-ны өдөр хүргүүлсэн болно.	1	50%

23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.		Хай Би Ойл ХК нь нийт 8 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүнээс компанийн хуулийн дагуу гүйцэтгэх захирал, нягтлан бодогч 2 эрх бүхий албан тушаалтан хамаарч байгаа болно. 2025 ондоо багтааж хамаарах журамдаа нэмэлт өөрчлөлт оруулж ажиллах болно.	1	50%
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	хэсэгчлэн хэрэгжүүлдэг	Гүйцэтгэх захирал Хөдөлмөрийн хуулийн дагуу Тусгай нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр ажилдаг бөгөөд нэмэлтээр урамшуулал олгох, гүйцэтгэлийн шалгуурыг тусгагдсан эрх зүйн бичиг баримт байхгүй болно. Гэрээний дагуу цалин сард 2 удаа олгогддог болно.	1	50%
ДҮН				3	0%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэрэгжүүлээгүй.	Хэрэгжүүлж ажиллана.	0	0%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Биелүүлж ажилладаг.	Жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан мэдээ, мэдээллийг дэлгэрэнгүй тайлагнаж ажилладаг.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Биелүүлж ажилладаг.	Компанийн вэб сайт дахь зохион байгуулалт болон мэдээ, мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Биелүүлж ажилладаг.	Компанийн ажилтнуудын санал хүсэлт өгөх, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх асуудлыг дотоод журмаар зохицуулдаг. /Дотоод журамаа хавсаргав./	2	100%
ДҮН				6	%

НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	Ёс зүйн дүрмийг баталсан.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Биелүүлж ажилладаг.	Комплайнсын хяналтын зааварт тусгасан болно.	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Биелүүлж ажилладаг.	Ёс зүйн дүрмэндээ тусгасан.	2	100%
ДҮН				6	100%
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Компани нь “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогын баримт бичиг”-ын хэрэгжилтийг ханган оролцогч талуудад хүргэх хугацаат мэдээллүүдийг МХБ болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлдэг. 2025 оноос эхлэн тухай бүр мэдээлэх мэдээллүүдийг цахим хуудсаараа дамжуулан тогтмол мэдээлэн ажиллана.	1	50%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэрэгжүүлэгч үй.	2025 оноос эхлэн хэрэгжүүлнэ.	0	0%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Биелүүлж ажилладаг.	Санхүүгийн охицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын зохицуулалтын дагуу холбогдох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох материалын жагсаалт, хуралд ирж оролцох	2	100%

			боломжгүй хувьцаа эзэмшигчдийн онлайнаар оролцох, санал өгөх, мэдээлэх авах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.		
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Биелүүлж ажилладаг.	Компани үйл ажиллагааны чиглэл, дүрмийн өөрчлөлт, нэмж хувьцаа гаргах зэрэг өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлуудыг ХЭХ-р хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.	2	100%
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Хай Би Ойл ХК нь улиралын чанартай үйл ажиллагаа явуулдаг ба 2024.11.01-2025.04.01-ны өдрийг хүртэл сул зогссон болно. Тайлант хугацаанд ямар нэгэн сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно. Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тохиолдолд нээлттэй мэдээлэлээд явах болно.	2	100%
ДҮН				6	
НЭГДСЭН ДҮН				54	

ТУЗ-ийн болон дэргэдэх хороодын 2025 оны хагас жилийн ажлын гүйцэтгэлийн тайлан

“Хай Би Ойл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх байнгын үйл ажиллагаатай Цалин урамшууллын хороо, Аудитын хороо болон Нэр дэвшүүлэх хороотой.

“Хай Би Ойл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, хороодын үйл ажиллагааны журамд заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын тус бүрийн 2025 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн тайланг доорх хүснэгтэнд үзүүлэв.

№	Хийгдсэн ажлууд	Давтамж/ хэлбэр	Гүйцэтгэл /Тайлбар
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 4 удаа санал асуулгаар хуралдаж доорхи асуудлуудыг хэлэлцсэн болно. Үүнд:			
1	2025 оны 01 сарын 06-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж А. “Эвиденсе аудит” ХХК-аар 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай, асуудлуудыг хэлэлцээд “Эвиденсе аудит” ХХК-аар аудит хийлгэх, гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захиралд даалгах шийдвэр гаргасан.	Ээлжит, саналын хуудсаар	
2	2025 оны 01 сарын 30-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж 2024 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлах эсэх асуудлыг хэлэлцэж 2024 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг гаргасан.	Ээлжит, саналын хуудсаар	
3	2025 оны 03 сарын 14-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг 2025 оны 04 сарын 25-ны өдөр хуралдуулхаар шийдвэрлэсэн.	Ээлжит, саналын хуудсаар	

4	2024 оны 05 сарын 14-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2025 оны 04 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар томилогдсон ТУЗ-ийн гишүүдээс ТУЗ-ийн дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж шийдвэрлэсэн болно. Мөн ТУЗ-ийн дарга гишүүдийг УБЕГ-ийн Хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгүүлэх шийдвэрийг гаргасан.	Ээлжит, саналын хуудсаар	
ТУЗ-ийн нарийн бичгийн даргын 2025 оны ажлын тайлан			
Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой			
№	Хийгдсэн ажилууд	Огноо	Хэлбэр
1	Компанийн 2025 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан хурлын зарыг өдөр тутмын сонин, Компанийн цахим хуудас, пэйжээр мэдээлэх, хувьцааны тархалтын мэдээг ҮЦТХ төвөөс авах, хурлын материал хэвлэж бэлтгэх зэрэг хурал хурадуулахтай холбоотой бүхий л бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн.	2025 оны эхний хагас жил	Ээлжит хурал, танхимаар хуралдсан болно.
Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралтай холбоотой			
2	Тухайн жилд хуралдсан ТУЗ-ийн ээжлит болон ээлжит бус хурлын зар болон хэлэлцэх асуудал түүнтэй холбоотой мэдээлэлийг ТУЗ-ийн гишүүдэд өгөх, санал авах ТУЗ-өөс батлагдан гарах тогтоолын төслийг бэлтгэх, хурлын тэмдэглэл хөтлөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн	Тайлант жилийн хугацаанд	Цахимаар